

Бил “Хүчлэх дусал” **МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ** сүүлийн дээр зохиогдсон
 Эрдэм шинжилгээний бичиг
Боть XLI (483) **Улаанбаатар** **2017**

ХАРЬ ГАРАЛТАЙ ҮГИЙН ХЭЛ ЗҮЙ

Н.В.Юшманов¹

Орос утга зохиолын хэлэнд харь хэлнээс орсон нэмэр хандив арвин бөгөөд олон талтай юм. Уул нэмэр хандивын дийлэнх чухаг хэсэг нь Европын бүх хэлийг хамраад эдүгээ Европ бус хэлнээ дэлгэр нэвтэрч эхэлж буй нийгэм-улс төр, шинжлэх ухаан-техникийн олон улсын чанартай нэр томъёог бүрэлдүүлж байна. Тэдгээр нэр томъёоны үндсэн хэсэг нь латин, герег хэлнээс, мөн нэлээд олон махбод нь өрнө дорнын шинэ хэлнээс бүтдэг.

Харь гаралтай үгийн хэлний зүйн зорилго нь уншигчдыг бичигт болон аман яриандаа олон улсын чанартай нэр томъёог ухамсартай хэрэглэж чаддаг болгох, хэлэнд нь хэдийнээ орсон олон улсын чанартай нэр томъёоны үндсэн категоруудыг түргэн, зөв, баттай эзэмшихийн хамт хэлэнд нь хараахан ороогүй байгаа нэр томъёоны утгыг ойролцоогоор боловч задлан ойлгож чаддаг арга барилтай болгоход оршино.

Орчин үеийн олон улсын чанартай нэр томъёоны дийлэнх нь латин, герег хэлнээ бэлтгэхэн байгаа үгээр биш тэдгээр хэлний махбод, загварыг ашиглан манай үед зохион бүтээсэн ба бүтээсээр буй шинэ маягийн үгээс бүрддэг тул ийм хэл зүйн бичиг эрхибиш хэрэг болно.

Харь гаралтай үгийн анхны туршилгын энэ хэл зүйн бичгийг үр ашигтай хэрэглэхийн тулд (I, II хүснэгтэд байгаа) латин, герег цагаан толгойг сайн мэдвэл зохино.

Томъёолсон тэмдэг

Сум	→ Үгийн хөгжлийн чигийг заана: <i>полюс</i> → <i>полярный</i>
Зэргэд	Үгийн тохироо, сэлгээг заана: <i>сим</i> <i>семит</i>
Зурдас	– Үгийг бүрэлдэхүүн хэсгээр нь зааглана: <i>пер-фор-а-тор</i>
Дөрвөлжин хаалт	[] Үгийн дуудлагыг ийм хаалтанд бичнэ.
Нуман хаалт	() Үгийн тогтвортой бус хэсгийг ийм хаалтанд бичнэ: <i>семит(иче)ский</i>
Дан хашилт	‘ ’ Үгийн /орос/ орчуулгыг үүгээр хашина: <i>‘виноград’</i> /усан үзэм/ ²

Дуудлага тэмдэглэдэг галиг үсгийг §I-3-рт тайлбарласан буй.

¹ Николай Владимирович Юшманов – (1896-1946) Хэлшинжлэлч, дорно дахин судлаач, араб судлаач. Тэрбээр олон хэлтэн байсны зэрэгцээ эрдэм шинжилгээний анхны өгүүллээ олон улсын зохиомол хэл бүтээх асуудалд зориулсан байна. Улмаар Петрградын Их Сургуульд суралцан араб хэл судлалын мэргэжил эзэмшсэн ба ЗХУ-д араб хэл судлалын үндсийг тавигчдын нэгд тооцогддог. Араб хэлний хэлзүйн гурван ч бүтээл туурвисан бөгөөд семит хэлний түүхэн хөгжлийн талаар мөн судалгаа хийсэн байна. Түүнчлэн амхар хэлийг судалсан Зөвлөлтийн анхны эрдэмтэн болжээ. Түүний алдартай бүтээлүүдийн тоонд *Грамматика литературного арабского языка* [Арабын утга зохиолын хэлний зүй] орох бөгөөд эрдэм шинжилгээний өндөр түвшинд бичигдсэнээрээ шинжлэх ухааны хүрээнд алдартай.

² Харь үгийн монгол орчуулгыг // ийм хаалтанд хийв. Орч.

АВИА

§1. Харь үгийн эгшиг авианы нэг хэсэг нь орос хэлнийхтэй таараад, нэг хэсэг нь таардаггүй. Иймд таарч өгдөггүй эгшгийг нь таардгуудын нь дунд тавиад авч үзэж болно.



агуу э (анг. а, лат. æ, герм. ä, фр. ai || è); орос хэлнээ е буюу э (§16), англи хэлнээ мөн а болдог³.



уруулын э (лат. œ, герм. ö, фр. eu || œu) орос хэлнээ (голдуу хоёр цэггүй) ё буюу э (§16) болдог⁴.



уруулын и (лат. у, герм. ü, фр. u) орос хэлнээ (эртнийхэнд нь ямагт) и, (орчин цагийн хэлэнд нь дандаа) ю болдог⁵.



агуу о (анг. а || о, гэхдээ авианы янз бүрийн нийлэмж болон зарим тохиолдолд); орос хэлэнд ва-ийн нийлэмжээс бусад үед о болж дуудагдана (§2).

Бас тод биш ялгараа бүхий нэлээд хэдэн эгшиг байдаг бөгөөд тэдгээр нь орос дуудлагаар уйтан ы (поль. у, рум. â || î), саармаг э (рум. ä, эстон. õ) агуу е болдог. Жишээлбэл: *дым, хобот, вода*, эрдэм шинжилгээний галигаар = *дым, хобот, вода*. Зонхилон англи хэлнээ байдаг в, э хоёр эгшиг орос хэл рүү орохдоо англи бичлэг, чихнээ сонсогдох авиа хоёрын хооронд баахан ацалмал байдалтай болсныг үзүүлбэл: *club, rum, trust* [клуб, ром, трест] → клуб⁶, ром, трест; *flirt, shirting, sir* [флэрт, шэтинг, сэр] → флирт, шёртинг, сэр гэх мэт. Баруун Европын хэлнүүд “ы” авианд төсөө боловч орос, польш хэлэнд уул авиа хатуу гийгүүлэгчийн дараа *идея* → б е з ы д е й н ы й гэх мэтээр “i” (и)-г орлож явдаг. Ер нь харь үгийг нааш нь буулгахад ы авиа гарч ирэх нь нэн ховор байдаг юм.

Хамаршсан эгшиг (польш. а, е, порт. ä, ö; порт., фр. хэлэнд үеийн эцсийн эгшиг + m || n) цаад хэлнийхээ бичлэгийн байдал, араас нь дагадаг гийгүүлэгчийн төрөл тэргүүтнээс шалтгаалан орос хэлнээ (уруулын эгшгийн өмнөх м аятай!) “м”, “н” хоёртой хоршсон ерийн нэг эгшиг шиг л буудаг нь: поль. *rząd, węzeł* → жонд, вэнзель; порт. *Magalhães, Camões* → Магеллaн, Камоэнс; фр. *champignon* → шампиньoн⁷ гэх мэт.

§2. Хос эгшиг бол хоёр эгшиг нийлээд ганц үе болж бүтдэг бөгөөд өгсөх (уйтан эгшгээсээ агуу өөдөө өгсөн: ор. я, ё, ю = йа, йо, йу), уруудах (агуу эгшгээсээ уйтан руугаа уруудсан ор. ай, ой, уй) хоёр янз байдаг. Үе бүтээдэггүй у (анг. w) бүхий хос эгшиг орос утга зохиолын хэлэнд байдаггүй боловч харь үгэнд бишгүйдээ бий. Уул хос эгшгийг орос хэлнээ “в”, “у” хоёроор буулгадаг. Анг. *Water, watt* → вaтeр, уaтт; лат. *autor, aula* → aвтop, áулa гэх мэт. Ялангуяа *gerer* хэлэнд түгээмэл байдаг эу (лат. eu) гэдэг хос эгшгийг орос хэлнээ ев || эв-ээр үл барам ей || эй (германаар eu хос эгшгийг өй гэж дуудна) гэж буулгадаг. Гр., лат. *Eucalyptus* → эвкалипт, эйкалипт, *neurasthenia* → неврастения, нейрастения гэх мэт. Үүнд “ав, эв” хоёрыг нийгмийн ухааны зүйлд, “ау, эй” хоёрыг байгалийн ухааны зүйлд голлон хэрэглэдэг байна.

³ Орос хэлнээс буулгасан жишээг IV хүснэгтээс үзмү.

⁴ Монгол хэлний ө. Орч.

⁵ Монгол хэлний ү. Орч.

⁶ Грибоедовын “Ухаантайн зовлон” гэдэг зохиолд энэ үгийг *клуб* буюу *член английского клуба* гэж бичсэн байдаг.

⁷ Жишээ болгосон хэдэн үгийн хамаршсан эгшгийг гэзгийн “-ээр [жo”д, вэ”ээд, мегельa”йш, камо”йш, ша”пиньo” гэж] галиглаж болно.

§3. Харь хэлний гийгүүлэгч нь орос хэлнийхтэй үндсэндээ таардаг. Харин “h”, “l” хоёрын тухайд бол онцлог зүйл бий.

“h” гэдэг (хөндий) авиа умард оросын аялгад байдаггүй. Оросын нийгэм анх латин хэлтэй умард нутгийн “r” авиаг “h”-аар дууддаг өмнөд нутгаараа (Украин) дамжуулан танилцсан юм. Чухам тэнд h нь r болоод хэл хэлэнд байдаг h мөн тэр янзаар орсон нь: *анг.* gas-holder, *гер.* hidrólysis, *исп.* hidalgo, *лат.* humus, *герм.* Hülse, *фр.* bohème → газгольдер, гидрoлиз, гидáльго, гýмус, ги́льза, богéма гэх мэт. Уг нь h авиаг х-аар дууддаг болгосонсон бол үнэн байдалд ойртох байсан юм. *Анг.* hockey, *герм.* Beethoven → хоккéй, Бетхóвен зэрэг цөөхөн үгэнд тийн хэрэглэж байна. Герег үгийн h авиаг нэг бол г-ээр дуудаад, нэг бол бүр орхидог. Жиш: (г)агиóграф, (г)иероглиф, (г)омóним гэх мэт. Гэхдээ харааны (харь хэлнээс орчуулах) тал дээр “r” нь, сонсголын (харийн хүнтэй ярих) тал дээр “x” нь голлож байгааг төвөггүй ажиглаж болно. Арабын “h” маягийн авиа л гэхэд Өрнөд Европын утга зохиолоор дамжихаараа (hidžra, hūri → гéджpa, рýрия гэх мэт) “r”-ээр, ЗХУ-ын лалын шашинт үндэстнээр дамжихаараа (Allāh, halwā → Алла́х, халва́ гэх мэт) “x”-аар орж ирдэг.

Тэс өөр “r”, “h” хоёр авиаг адилхан “r”-ээр буулгаж байгаа нь эндүүрэхэд хүргэж мэдэх юм. Контрагeнт (*лат.* contrahens, үндэс нь contrahent-) гэдэг үгийг контр-агeнт гэж (*лат.* agens, үндэс нь agent-тай) буулгаж бичих нь цөөнгүй байна. “l” авиа хатуу “ль”, зөөлөн “ль” хоёрын дундуур дуудагддаг. Үүнээс уламлаад орос хэлэнд нэг үгийг: *лат.* lupinus → лупин || люпин; manuāl → мануáл, тэгсэн атлаа pedāle → пeдáль гэх мэтээр ямагт хэлбэлзэлтэй бичиж байна. Англи хэлний “l”, үеийн эцэст хатуу “ль” мэт дуудагддаг боловч орос хэлнээ ямагт зөөлөн “ль” болдог нь: ale, bill, rails [эйл, бил, рэйлз] → эль, биль, рельс гэх мэт. Франц хэлний “-ill” эдүгээ “й”-ээр дуудагддаг болсон хэдүй боловч орос хэлнээ хуучин хэвээр, Францын өмнөд нутгийн аялгууг дуурайн “ль” гэж дуудсаар байгаа нь: billard, mitrailleus, taille [бияр, митрайoз, тай] → бильярд, митральеза, тaлия гэх мэт.

Орос хэлнээ байдаггүй бусад гийгүүлэгч цөөн бөгөөд тэдгээрийг хэрхэн буулгах талаар нэгэн мөр болгож тогтоосон зүйл ч үгүй байна.

Тайлбар: Латин цагаан толгойн үсгийг латин бичиг бүхий хэлтнүүд өөрийнхөөрөө янз янз дууддаг тул төдий л нарийн эс мэдэх хэлнээсээ манайх буруу дуудлагаар буулгасан нь олонтоо тохиолддог. Жишээ нь:

Итали хэлнээс

aggio [áджo] → áжиo
breccia [брéчча] → брéкчия
imbroglio [имбрóльo] → имбрóглиo
mezzo [мэ́дзo] → мéшo

Испани хэлнээс

guerrilla [гэри́лья] → гвeри́лья
llama [ля́ма] → ла́ма /гөрөөс/
peseta [пэсэ́та] → пeзéта
quipu [кíпу] → кви́пу /зангилмал бичиг/ гэх мэт.

Тэр ч атугай *фр.* eau-de-Cologne [одoкoлoнь] /Кельнийн ус/ гэдэг үгийг oдeкoлoн гэж ташаа буулгасан байна.

§4. Орос хэлний өргөлт (мүка/зовлон/ || мука/гурил/ гэх мэт) нь үгийн утга, (руки/гарнууд/ || руки/гарны/ гэх мэт) үгийн хэлбэр ялгаагүй үедээ ер нь сүрхий хэлбэлзэлтэй байдаг. Тэр дундаа янз бүрийн сурвалжаас, янз бүрийн цагт, янз бүрийн замаар орж ирсэн харь үгийн тухайд бол бүр ч илүүтэй байна. Орос бичигт тэдгээр үгийн хэрэглэгдэхүүн (гэхдээ нэг бүрчлэн ч биш ээ) дотор (утга зохиолын хэлэнд ямагт өргөлттэй байдас ё-оос бусад) өргөлт бүхий үеийн эгшиг дээр өргөлтийн тэмдэг (´) тавьсан байдаг юм. Хэлбэлзлийн тухайд гэвэл нэгэн амиар хоёр янзын хэлбэлзэлтэй дуудах ч тохиолдол байна. Орос үгэнд орсон харь үгийн өргөлтийн хэлбэлзэл эн чацуу хоёр (юм уу түүнээс дээш) байх нь олонтаа байдаг.

<i>гер.</i> →	<i>лат.</i> →	<i>ор.</i>
epilépsia	epilépsia	эпилéпси́я
kathédra	cáthedra	кафédра
periphéria	periphéria	перифéрия
<i>гер. / лат.</i> →	<i>герм⁸.</i> →	<i>ор.</i>
catálogus	katalóg	катáлог
astrónomus	astronóm	астрóно́м
manómetrum	manométer	манóмéтр

Польш хэл (араасаа хоёр дахь үе дээрээ өргөлттэй)-ээр дамжин ирсэн үгийн өргөлт уг байх үеэсээ өөрчлөгдөн шилжинэ: *лат.* fundaméntrum → *поль.* fundáment → *ор.* ф у н д á м е н т⁹.

Харь гаралтай үгийн өргөлтийн хэм хэмжээг нилээд тогтвортой байдаг шинжээр нь:

Герегийн: холбох эгшиг “-о-” (т е р м ó м е т р); угтварын хоёрдугаар эгшиг (д и á м е т р); §36-д тэмдэглэсэн дагаврууд;

Латины: үгийн эцсийнгийгүүлэгчийн өмнөх эгшиг (к о л л é г а, м и н е р á л, р á д и й), гэхдээ -ег-, -ис-, -ог-, -ул- гэдэг нийлэмж дээр бол тогтмол биш (н ú м е р || н ó м е р, г у м м и - а р á б и к, м á т р и ц а, á в т о р, о р á к у л, к á п с ю л ь) гэж ангилж болно.

Гэхдээ энд тохиолдол тус бүрийг, тэр дундаа үгийн хэлбэрийг нэлээд өөрчилдөг тийн ялгалын нөхцөлийн (§38) талаар дурдсангүй.

§5. Харь гаралтай үгийг буулгахад гардаг өөрчлөлт нь:

а. Орос хэлний цагаан толгойд яв цав таарах тэмдэг нь байдаггүй ä, ö, ÿ, å, в, э, ъ, h, l: *анг.* Mary, Wallace, Ruskin, Holmes [мáри, ўалэс, рескин, хоўмз] → Мáри || Мéри, Báллас || Уóллес, Рáскин || Рёскин, Гольмс || Холмс гэх мэт.

б. Орос хэлэнд янз бүрийн замаар тухайлбал, амаар буюу бичгээр, шууд буюу өөр хэлээр дамжин орж ирсэн үгс жишээлбэл, герман хэлний “о” амаар зээлдсэн үгэнд “у” болоод (*герм.* Franzose, Reithose → ф р а н ц ú з, р е й т ú з ы), бичгээр зээлдсэн үгэнд “о” хэвээрээ (*герм.* Rote Fahne → Р ó т е Ф á н е, Vorschmack → ф о р ш м á к) орж иржээ. *Герм.* bohren → б у р (á в) и т ь || bohrmaschine → б о р м а ш и́ н а хоёрыг жишиж үзмү. Герман хэлээр дамжсан *герм.* ischias, trapézion, *лат.* spatium, glycōsa (исхиас, трапезия оспация, гликоза)-ийн оронд и́ ш и а с, т р а п é ц и я, ш п á ц и я, г л ю к ó з а болсон байна.

в. Нэг хэлнийх атлаа өөр өөрөөр дуудагддаг үгс. Герег хэлний үг эразм (хуучин), рейхлин (шинэ) (II хүснэгтэд үзмү) хоёр янзаар дуудагдан зөрсний жишээ нь:

⁸ “-ог” төгсгөлтэй латин үг герман хэлэнд ороход уг бүтээвэрт өргөлт шилждэг. Үз.: *Diréktor* || *Direktören*, *Kommutátor* || *Kommutatören*, *Revisor* || *Revisören*.

⁹ Хуучин цагт фундамент (Гёлтергоф 1771, Рейф 1829) гэдэг байсан бөгөөд ер нь тэр үед иймэрхүү үгийн өргөлт нь -мент дээрээ байдаг байжээ.

(Р) Ара́вия, еврей, орфогра́фия, Сим...

(Э) ара́б, гебраи́ст¹⁰, ортопе́дия сем'т...

г. Эдгээр бүх шалтгаан нь харь гаралтай үгсийг жигдлэн журамлахын аргагүй болтол хоорондоо сүлжилдэн хэвшчихсэн байдаг ажээ. Ялангуяа лат. с, е, l, s дөрөв ихээхэн өөрчлөгддөг бөгөөд е, l хоёр нь бүхий л тохиолдолд (№2 ба 3), с, s хоёр нь тодорхой нөхцөлд (§7 б, в) хэлбэлздэг юм. Ийм маягаар бий болдог зөрүү нь, ялангуяа нэг үүрийн үг гектоуáтт || килова́тт (анг. w, §2); прое́кция || проже́ктор (лат. j = герман хүн [й], франц хүн [ж] гэж дууддаг; денти́н || данти́ст фр. dent /шүд/ дуудлага нь [да^н], §1) гэж өөр өөр болсон нь харь гаралтай үгийг судалж зөв хэрэглэх тухайд төвөг учруулж байна.

§6. Салаалал: Янз бүрийн сурвалж дамжин орж ирэхдээ хэлбэр нь ч, утга нь ч үл ялиг өөр өөр болон салсан нэг үгийн тухайд үгийн салаалал гарч ирж байгаа юм. Жишээлбэл, аги́тáция || ажи́тáция, бенефи́ция || бенефи́с, када́нс || каде́нция, майо́р || мажо́р, прое́кт || проже́кт, сви́та || сюи́та, тра́πεζа || трапе́ция гэх мэт. Гав ганц үг лат. magister → магни́стр, маэ́стро, ма́стер, ми́стер, -мэй́стер (гофмэй́стер), -ми́стр (ро́тмистр), метр (фр. maître d'hôtel, метр-д-отель: мөн метранпа́ж ← фр. metteur en pages 'хэвлэлийн хуудас боогч') болсныг үзэгтүн. Үүнтэй ойролцоо үзэгдэл гэвэл язгуур ч нэгтэй, хэрэглэгддэг салбар ч нэгтэй атлаа өөр өөр дагавраар хэлбэрждэг аликвáнтный || аликвóтный, сегме́нт || се́ктор, сталакти́т || сталагми́т зэрэг хос нэр томъёог дурдаж болно. Иймэрхүү ихэр үгсийг хооронд нь хутгаж самуурахад амархан байдаг.

§7. Сэлгэлт: Үгсийн бүрэлдэхүүнд (үндэс, залгавар болж) ордог нэг махбодын доторх авиа янз янзаар дуудагдахыг ийн нэрлэдэг. Гэхдээ тэдгээр нь өөрчлөлт (§5), салаалал (§6)-тай адилаар дуудах маяг, дамжин ирсэн замаасаа шалтгаалан тийм болоогүй байна.

а. Олон улсын нэр томъёонд эгшиг авиа сэлгэдэг үзэгдэл бол их эртнээс уламжлан ирсэн зүйл бөгөөд эдүгээ ч тээр болсоор үгийн угаас нэг язгуур (√)-ыг салган холдуулсан хэвээрээ явж байна.

гер. √βλ	'бросать' /шидэх/	→ балли́стика дискобо́л пробле́ма
гер. √fry	'делать' /хийх/	→ эне́ргия о́рган метталлúрг ¹¹
гер. √fr	'носить' /авч явах/	→ перифе́рия семафо́р
гер. √ly	'говорить' /ярих/	→ пролего́мена проло́г

(дээрх хоёр мөрийн жишээг орос хэлнй везу || воз, несу || носить гэдэг үгстэй харьцуулан үзмү)

лат. √fc	'делать' /хийх/	→ факт перфе́кт квалифика́ция
лат. √pl	'толкать' /түлхэх/	→ пропе́длер /түлхэн оруулагч/ пу́льс

б. æ, е, i, œ, у-ийн өмнө орсон лат. "с" нь эдүгээ "ц"-ээр дуудагддаг тул "к"-ээр эхэлсэн язгуурт к || ц сэлгэж байдаг.

лат. √cd	'падать' /унах/	→ каде́нция рециди́в, инциде́нт
лат. √cn	'петь' /дуулах/	→ ка́нтор акце́нт (§8)
лат. √cp	'брать' /авах/	→ ка́псюля акце́пт (§8) перципи́ровать

¹⁰ эбраи́ст гэсэн хэлбэр нь эртдээ жүүдүүдийн өөрсдийгөө нэрлэж байсан нэрийн (ibrit) семит хэлний төвөнхийн h гийгүүлэгчийг дууддаг грек дуудлагыг залруулж буй явдал болно. Одоо харин хуучны дуудлага ноёлох хандлагатай байгаа тул сүүлийн үеийн дуудлага бүхий олон үг хэрэглээнээс хасагдаж байна: андоло́гия → антоло́гия, вивлю́бика → библио́тека, ирой → геро́й, пийть → поэт, театрь → теа́тр.

2.2 в. Хоёр эгшгийн дундах *лат.* “s”-г эдүтээ “з”-ээр дуудан мөн л язгуурын дуудлагыг ацлуулсаар байна. Жиш: sector || prosēctor → сэ́ктор || прозэ́ктор, absolution || resolutio → абсолю́ция || резолю́ция. Шинээр бүтсэн нийлэмж үгэнд бол заавал ийм байх албагүй. Жиш: vivisection → вивисе́кция

г. “с-“, “-s-“ хоёрын эдүгээгийн дуудлагын дүрэм нь латин маягаар хэлбэржүүлсэн герег үгэнд бас халдан дэлгэрч байна. Жинхэнэ герег дуудлага ($\chi = \text{к}$, $\sigma = \text{с}$), латин дуудлага хоёрын хооронд цөөнгүй тохиолдолд сэлгэж байна. Жиш: cystitis → кисти́т || цисти́т, Theosophia → теосо́фия || теозо́фия гэх мэт.

д. Үгийн үндсийн эцсийн к || ц, т || ц сэлгэдэг. Гэвч эдгээр нь шинэ шинэ нэр томьёонд тасралтгүй залгагдан орж явдгийн дээр ер нь үгийн сүүл туслах үүрэгтэй байдаг тул үгийн утгыг тэр бүр ацмалжуулж салгадаггүй юм. Жиш: меди́к || медици́на, фармако́логия || фарма́ция, препа́рат || препара́ция гэх мэт. Орос хэлний үг бүтээх ёс нь харь гаралтай үгэнд истори́к → истори́ческий, мона́х → мона́шеский, секре́т → секре́чвать, студе́нт → студе́нский гэх мэт нэмэгдэл сэлгээ үүсгэх тал бий.

е. Аливаа хэлэнд дуудлага нь зөрдөг аман аялгуунууд байдаг. Олон улсын нэр томьёонд тэр зөрөө туссан байдаг юм. *Гер.* демаго́т || страте́г, ста́тика || систе́ма; *араб.* ка́ди || кази́й, рамада́н || рамаза́н гэх мэт. Орос ардын аман аялгуунд хэлний дундуурх гийгүүлэгч байдаг бөгөөд тэдгээрийг олон улсын авианы цагаан толгойд с, j-ээр тэмдэглэдэг юм. Тухайлбал, кирпи́ч [kirpits], а́нгел [angel] гэхийн оронд тирпи́ч [cirpits], а́ндел [anjel] гэх мэт. Эдгээр амаар дамжин орж ирсэн зээлдсэн үгт хэлний дундуурх гийгүүлэгчээс болоод тонгоруу сэлгээ гарах нь цөөнгүй бий. Жиш: *герм.* kringel → кре́ндель, fiedler → фи́гля́р, *сканд.* viking → ви́тязы; *лат.* sum̄inum → ти́мнин гэх мэт.

§8. Нэг нь үгийн үндсэнд, нөгөө нь угтвар (оруулбар, дагавар)-т байгаа хоёр өөр авиа уулзалдахад ижилшил явагддаг. Хоёр өөр авиа уулзалдахдаа нэг нь нөгөөдөө автан ав адил дуудлагатай болбол бүрэн ижилшил, хоёр өөр авианы нэг нь нөгөөдөө татагдан арай өөр дуудлагатай болбол заримдаг ижилшил болно. Доорх угтваруудыг залгахад бүрэн ижилшил болно:

1) *лат.* ад- /-д, хажууд/

агрега́ция

аккомода́ция

адлита́рация

анно́тация

апперце́пция

арро́зация

ассимиля́ция

аттеста́ция

аффи́лиация

2) *лат.* дис- /салах, бутрах/

диффу́зия

3) *лат.* ин- /дотор, -гүй/

иллю́зия

- иммиграция
иррадиация
- 4) *лат. кон-* /хам/
коллекция
коммерция
коррекция
- 5) *лат. об-* /-д, дээр/
оказия
официант
оппозиция
- 6) *гер. син-* /хам/
силлогизм
симметрия
- 7) *лат. суб-* /доор/
суггестия
суккуссия
суппозиторий
суррогат
суффикс
- 8) *лат. суб-* /доор/
эффэкт
- 9) *гер. эн-* /дотор/
эллипис.

Эдгээр үгийн бичлэгийг §16-д үзмү. Угтвар ад- адрогация, адскриция зэрэг (хуучирсан) үгэнд хэвээрээ үлдсэн байна. *а, е, і, а*, у-ийн өмнө орсон *лат. "с"* нь "ц"-ээр дуудагддаг тул *ад-, об-, суб-* угтварууд уул "ц"-ийн өмнө орохоороо *ак-, ок-, сук-* болдгийн жишээ нь: акцент, окциденталь гэх мэт. Мөн суггестия гэдэг үгийг (*фр. "д"* нь *е, і*, у-ийн өмнө орохоороо "ж"-ээр дуудагддаг тул) сугжестия гэх нь ч байдаг. *Лат. интер* /хооронд, завсар/ гэдэг угтвар зөвхөн интеллигент, интеллект гэдэг үгэнд (авиа ижилшиж-орч.) ордог. *Лат. экс-* гэдэг угтвар 'асан, байсан' гэдэг утгаараа ер нь хэрэглэгддэггүй. Харин *экс-фискал* гэх мэт үгэнд орж явдаг.

Заримдаг ижилшдэг угтварууд:

- гер. эн-* /дотор/
эмблема
эмпирик
эмфазис
- лат. ин-* /дотор; -гүй/
имбибиция
императив

лат. **кон-** /хам/

комбинация

компания

гер. **син-** /-тай⁴/

симбиоз

симпатия

симфония

гэсэн хэдий боловч информация, конференция гэдэг үгст ин-, кон- утгваруудын -н гийгүүлэгч ижилшээгүй байна. Гер. палин- /дахин, сөөргөө/ гэдэг утварыг /ф бүхий палимпсест /хусах/ гэх мэт ганц нэгхэн үгэнд хэрэглэж байна.

Дагаврын авиа бүрэн ижилших явдал гер. -ма дагавартай үгэнд: телеграф → телеграмма; заримдаг ижилших явдал лат. үгийн “хоёр дахь үндсэн”-д тохиолддог (§34). Олон улсын ердийн бичлэгт утгварын (дуутай гийгүүлэгч дуугүй болох, дуугүй нь дуутай болох зэрэг) дууны өөрчлөлтийг огт тусгадаггүй. Үнэндээ гэхэд лат. абсолют, обсерватория, гер. экзема гэдэг үгсийн эхэнд апс-, опс-, эгз- л дуудагдаж байгаа юм.

§9. Ижил буюу нэг төрлийн хоёр авиа нэг үгэнд ороход ондоошил (диссимиляция) гардаг. Орос ардын хэл ярианд харь үгийн р...р нь л...р болж ондоошдог. Жиш:

директор, коридор, револьвер, рёкрут, рыцарь ...

дидектор, калидор, девольверт, декрут, дыцарь ... гэх мэт. Мөн “м+уруулын гийгүүлэгч” нь “н+уруулын гийгүүлэгч” болж ондоошдог. Жиш: бомба, лампа, трамвай → бонба, ланпа, транвай гэх мэт.

Олон улсын нэр томьёонд хоёр зүйлийн ондоошил тохиолддог нь:

лат. -аль- дагавар өмнөх үгийн үндсэнд байвал -ар- болдог. Полярный, окуляр, элементарный гэх мэт. Гэвч легальный, филиал гэх мэт үгэнд хэвээрээ үлдсэн нь ч бас бий.

“и”-ээр төгссөн үндсийн араас залгасан гер. -д, -изм, -ик, -ист, -ит дагаврууд -ад, -азм, -ак, -аст, -ат болдог. Илиада, хиазм, маниак, энтузиаст, азиат гэх мэт. Герегээс өөр хэлний үгийн үндсэнд залгавал копиист || копист гэх мэт хэвээрээ явдаг ёс бий.

§10. Эгшгийн уулзвар (хиатус). Нийлмэл үгэнд хоёр эгшиг уулзах бөгөөд зарим тохиолдолд түрүүчийнх нь эгшиг гээгддэг.

Герег үгэнд нийлмэл үгийн хоёр дахь гишүүн буюу үндэс нь эгшгээр эхэлсэн байвал утгварын нь сүүлийн эгшиг юм уу холбох “-о-” нь гээгддэг. Метонимия (гэсэн атал мета-физика), невр-алгия (гэсэн атал невропатия) гэх мэт. Нийлмэл үгийн хоёр дахь буюу хойд үг нь гийгүүлэгчээр эхэлсэн байвал зоолог гэх мэтээр холбох “-о-” нь хэвэндээ байдаг юм. Дагавар залгахад зөвхөн ижил хоёр эгшиг дараалан ордоггүй (§9-д үзмү), бусад нь бол дараалан ордог. Жиш: акмеизм, архаизм, эгоизм гэх мэт.

Латин үгэнд хоёр эгшиг ижил ч бай, ондоо ч бай ямар нэг өөрчлөлтгүйгээр дараалан орно. Жиш: ко-операция, кони-ин, альтру-изм гэх мэт.

Герег, латаин үгэнд бусад хэлний махбод залгахад эхний үгийн нь сүүлийн эгшиг кокаи́н, лама-и́зм, шинто-и́ст гэх мэт үгэнд хадгалагдан явдаг байхад будди́ст (← Будда), пиа-ни́ст (← форте-пиано), кавалери́ст (← кава-лэ́рия) гэх мэт үгэнд гээгдэх жишээтэй байна.

“h”-аар эхэлсэн герег үгийн үндсэнд угтвар залгахад уул угтвар эцсийнхээ эгшгийг гээдгээр үл барам үндсэн үгийнхээ эхний “h”-г ч шахан гаргадаг. Жиш: *hodós* /зам/, *анод* (ана-), *период* (пери- гэдэг угтвар бол эцсийнхээ эгшгийг ямагт хадгалж явдаг юм), *синод* (син-), *эпизод* (энд эпи- мөн ховор тохиолддог *eis*-, из- хоёр угтвар давхарлан оржээ) гэх мэт. Герег хэлний эразм, рейхлин хоёр янзын дуудлагын аль алинд нь апо-, эпи-, гагц рейхлинийхээр ката-, мета- гэж дуудагддаг энэ хэдэн угтвар афелий (*ap-hélión*), кафедра (*kat-hédra*), Мефодий (*Met-hódios*), эфемерида (*ep-hémeris*) зэрэг нийлмэл үгэнд *аф-*, *каф-*, *меф-*, *эф-* болж явдаг юм. Ийм болохоор *а ф о р и з м* (*ap-horismós*), *г о р и з о н т* (*horizōn*) гэдэг үгс хоёул *гер.* *hóros* /хязгаар, зааг/ гэсэн үгээс үүссэн хэдий боловч орос хэлнээ орсон хэлбэрээ нь харвал хоорондоо холбоотой ямар ч шинж алга. Герег хэлний хэрэглэгдэхүүнээс техникийн латин хэлэнд суурилан бүтсэн нийлмэл үгэнд бол дунд нь орсон “h” хадгалагдан үлджээ. Жиш: *а н г и д р и д* ← *anhydrid*, *перигелий* ← *perihelium*, *сингарминизм* ← *synharmōnismus* гэх мэт.

§11. Нийлмэл үгийн дунд ижил буюу төсөөтэй хоёр үг дараалан орвол үе гээгдэх (гаплогия) үзэгдэл гардаг. Жиш: *минера(ло)логия*, *католо(го)графия*, *ир(ид)ит*, *траги(ко)комедия*, *инте(грало)граф*, *эклeкт(иц)изм*¹¹. Гэхдээ энэ бол хууль биш, эс баримталсан ч болох зөвхөн байх бололцоотой л зүйл (*ер* нь *haplogia* гэдэг нэр томъёо ч өөрөө тийм бат нут юм биш!) бөгөөд нотолгоо ч хангалттай.

филология	родоэндрон
автотомия	ангелолатрия
гидродром	параллелепипед

Дээрх хоёр бололцоог тэлээлж явдаг үгс байдаг ба жишээлбэл, *пневмато-терапия* || *пневмо-терапия* гэх мэт.

§12. Авианы гээгдэл (синкопа). §10-т дурдсан тохиолдлоос гадна ердийн түргэн ярианд өргөлтгүй үеийн эгшиг бас гээгддэг. Жиш: *гер.* *apothēca* *лат.* *regulamētum* *аптека*, *регламент*, *спирт* гэх мэт.

Зарим хэлэнд тэг (хэлбэр)-тэй амархан сэлгэдэг (дуудсангүй гээд ойлгоход саад болдоггүй) богино эгшиг байдаг бөгөөд тухайн үгийг нэг хэлнээс нөгөөд ороход тийм эгшиг нь зүгээр л алга болдог байна. *Фр.* *decollete* → *декольтэ*, *paletot* → *пальто*, *яп.* *jinrikisha* → (*джин*) *рикша*, *mogūsa* → *моска* гэх мэт.

Хэдэн гийгүүлэгч нэг дор ороход нэг нь гээгдэх явдал байдаг. *Гер.* *ан-* /-гүй/ гэдэг угтвар нь эгшиг юм уу “h”-ийн өмнө хэвээрээ ордог: *ан-оним*, *ан-од* (← *hodós* /зам/) гэх мэт. Өөр тохиолдолд *а-политичный* гэх мэтээр дан “а-” болно. *Лат.* *амб-* /эргэн тойрон/ гэдэг угтвар эгшгийн өмнө *амб-иция* гэх мэт хэвээр байдаг бөгөөд бусад тохиолдолд *ам-путация* гэж өөрчлөгдөж “ам-” болно. §8-д өгүүлсэн угтваруудын тухайд тэд зарим нэг гийгүүлэгчийн өмнө орохоороо (доорх жишээнд үзүүлсэн маягаар) төгсгөлөө баахан хялбаршуулдаг.

ад- /-д, -руу/

аспирация

асценденция

дис- /хуваа-/

дивизия

директор

транс- /алгас-, шилж-/

¹¹ Англи хэлний *eclecticism* гэсэн үгтэй харьцуулж үзвэл -ic гэсэн үе нь гээгдээгүй байгаа нь мэдэгдэнэ.

традиция

траектория

транскрипция

экс- /-аас⁴/

эволюция

эдикт

элеватор

эмигрант

энуклеация

эрекция

экспирация гэх мэт.

Лат. “экс-” утгвар “байсан, асан” гэдэг утгаараа *эксминистр* зэрэг үгэнд хэвээрээ байдаг бөгөөд гер. “экс-” /-аас⁴/ утгвар гийгүүлэгчийн өмнө орохоороо *ан-ек-дот* гэх мэтээр төгсгөлөө гээж явдаг юм. Лат. “аб-” /-аас⁴/ утгвар “с”, “т”-ийн өмнө орохоороо *абсцес*, *абстинент* гэхчлэнгээр “абс-” болдог (бөгөөд *транс- || тра-* хоёрын сэлгэдэг *ёснь* үүнтэй адил болно). Лат. “кон-” /хам, -тай⁴/ утгвар эгшиг юм уу амьсгалын түрэлтэт “h”-ийн өмнө орохоороо хамрынхаа “н”-ийг гээдэг: *коадьютор*, *когорта* [h] гэх мэт. Тооны ухаанд ‘нэмэлт’ утгаар орохдоо уул утгвар “н”-гүй болдог. Жиш: *кóсинус*, *котáнгенс*, *косéканс* гэх мэт.

Франц үгийн эцсийн гийгүүлэгч тогтвортой биш байдаг. Гэхдээ франц хэлний зөв бичих зүйн ёсоор дууддаггүй тохиолдолд ч эцсийн гийгүүлэгчийг бичсээр байдаг билээ.

Портъё́ (portier), *сабо́* (sabot), *ко́р* - /бие/ (corps), *бу́ржуа́* (bourgeois), *но́рма́н* (normand)

Портъёра́ (portiere), *саботаж* (sabotage), *ко́рсёт* (corset), *бу́ржуа́зия* (bourgeoisie), *но́рма́ндия* (normandie)

Франц хэлний авиа зүйн хуулийн дагуу *meurt* /үхэж байна/ || *mourens* /үхэжээж байна бид/, *neuf* /шинэ/ || *neuve* /шинэ/ гэдэгчлэн *Бабе́ф* (Babeuf) гэдэг үгээс *бабуви́зм*, *бабуви́ст* гэдэг үгс бүтжээ.

Орос хэлнээ орж ирэхдээ гээгдсэн эцсийн гийгүүлэгч ер сэргэдэггүй. Жиш: харилцааны аппарат *бодо́* (Baudot) → *боди́ст* гэх мэт.

ҮСЭГ

§13. Оросын бичиг хард заримдаа латин, герег үсэг холилдон орж явдаг нь: 1) орчуулж буй эхийн доторх: *est modus in rebus* /юманд хэмжээ байдаг/, *pánva péi* /юм нэгээрээ байдаггүй/ гэх мэт эшлэл, хэллэг; 2) Анагаах ухаан, байгалийн шинжлэл, хууль цаазын ухаанд голдуу хэрэглэдэг латин гаралтай) тэр бүр орчуулагддаггүй, өвөрмөц шинж бүхий: *Cholera asiatica* /Азийн урвах тахал/, *Pyrrhula vulgaris* /божирго/, *Judicium ignis* /галаар эрүүдэх/ зэрэг нэр томьёо; 3) H_2O /ус/ устөрөгчийн хоёр атом = *hydrogenium*, хүчилтөрөгчийн нэг атом = *oxygenium*, etc. = *etcætera* /гэх мэт/, μ = *микрон* зэрэг хураасан нэр томьёо, хэмжүүрийн нэгжийн нэр; 4) дугаар: гурвалжны “ α өнцөг”, “ ζ Геркулеса” /одны Г ордын тав дахь од/ гэх мэт. Зүйлийн дугаарт орос хэлний “а, б, в...”-ийн оронд “а, в, с...”-г хэрэглэх; 5) Гадаад хэлний оноосон нэр, ялангуяа латин бичигтэй үндэстний овог нэр “Röntgen’a туяа” гэх мэт.

Орхиос ' (апостроф) гэдэг таслуур тэмдгийг орос бичигт *фр.* Table d'hôte → т а б е л ь - д ' о т ; оноосон нэрд ямагт хэрэглэдэг d'Arsonval → д ' А р с о н в а л ь (гэсэн атлаа → д а р с о н в а л и з а ц и я) гэх зэргийн тодорхой зүйлд хэрэгдэдэг.

Латин, герег үгийг (цахилгаан мэдээгээр нэвтрүүлэх зэрэг) зарим тохиолдолд “эст модус ин ребус” ← *est modus in rebus*, “панта рей” ← *pánva rei* гэх зэргээр орос цагаан толгойн үсгээр буулгадаг бөгөөд тэгэхдээ латин, герег үсгийг “зета геркулеса”; x^2 = “икс в квадрате” гэж нэрээр нь бичдэг.

§14. Латин цагаан толгойн үсгийг хэл хэлнээ янз янзаар нэрлэдэг. Ерөнхий төлөв нь орос хэлэнд нэрлэдэгтэй ойролцоо боловч дуудлага нь зөрөөтэй байдаг юм. Тийн зөрдөг нэрс гэвэл:

анг.	исп.	ит.	герм.	порт.	фр.
Н эйч	аре	акка	ha	егá	аш
J джэй	хота	улунго	йот	жотие	жи
W дабл'ю	...	доппио ву	вэ	деблию	дублвэ
X экс	эксис	икс	икс	шиш	икс
Y ўай	игриэга	ипсилон	ипсилон	ипсилон	игрэк
Z зэд	сэта	дзэта	цет	зэ	зэд

Герег цагаан толгойн үсгийг орос хэлнээ шинжлэх ухаан-техникийн зүйлд зөвхөн эразмын нь дуудлагаар (θ = тета гэнэ, фета гэхгүй) нэрлэдэг. Тэдгээр нэр нь үг хэллэг бүтээхэд ч орно. Жиш: *альфа и омега; дельта Нула; этацизм и итацизм; нина иоту; ротацизм; сигмоид* (S хэлбэр); *хиазм* гэх мэт. Латин үсгийн нэрээс орос хэлнээ -(й)ный төгсгөлт¹² *энное количество* (алгебрийн n тоо), *бейный и эсний басы* (үлээвэр хөгжмийн B = си бемоль, Es = ми бемоль) зэрэг хавсрал нэр үүсгэдэг.

§15. Гадаад зарим нэг үг хийгээд оноосон нэрийн зүйлд ордог үсгийн зурлагыг аль болохоор нарийн хийхгүй бол олонх уншигч, сийрүүлэн бичигч, үсэг өрөгчид эс гаргаж уншин, будлихад хүрдэг. Хамгийн их анхаарах үсэг гэвэл: 1) орос хэлний цагаан толгойн бичмэл *лз* (“м”-тэй төстэй), *zu* (“ш”-тэй төстэй), *sp* (“ф”-тэй төстэй) 2) латин цагаан толгойн бичмэл толгой үсэг *F, T, I, J*-г хооронд нь ямагт хутгадаг *I, L* (*H*-тэй төстэй), *in, ni* (“т”-тэй төстэй) үсгүүд юм. Гаргац муутай бичигт орос хэлний *т, ш* дээр доор нь ялгах зураас эс татваас мөн орос, латин цагаан толгойн *и, n* хоёр ялгаагүй болдог. “*r*” үсэгт бичмэл *r, ʒ* хоёр өрсөлдөж явдаг бөгөөд түрүүчийнхийг нь “*v*” гэж унших удаа ч цөөнгүй бий. Энэ мэтээс болоод олон улсын хэрэглээнд мадагтай орсон үг гэвэл *з е н и т* (*араб. sāmt* → *zenth* гэж байсны оронд хуучин испани хэлэнд *zenith* гэж оржээ), орос хэлний *к о н в е р т* хоёр байна. Франц хэлний *convert* (өөрөөр хэлбэл куверт)-ийн оронд *convert* гэж алдаатай бичсэнээс уламласан бололтой.

§16. Орос хэлнээ гадаад үгийг зөв бичих зүй зохиогч орчуулагч нар гадаад хэлнээс үгийг янз бүрээр буулгадгаас (§1-3), мөн орос хэлний зөв бичих зүйн зарим нэг, ялангуяа “э” үсэг, давхар гийгүүлэгч хоёрын тухайт маргаанаас болоод нэлээд хэлбэлзэлтэй байна.

а. “э” үсгийн тухайд олонх зохиогч (украин, болгар, серб бичгийн үлгэрээр) уг үсгийг орос хэлний цагаан толгойгоос бүрмөсөн хасах, “э” (æ, е, œ...) авиа бүхий бүх гадаад үгэнд хэрэглэх гэсэн хоёр хэтэрхийллийн дундыг барьсхийж явна. Дээрх хоёр хэтэрхийлэл орос хэвлэлийн зүйлд тусгалаа олсны жишээ нь:

гиэна	кафе	тема	проэкт
гиэнэ	кафэ	тэма	проэкт...

¹² *N-ский полк, N-ская дивизия* гэх мэт нууцалсан нэрүүдийг уншихдаа Московский, Володарская гэдэг шиг Энский, Энская гэж дуудна.

Уг нь үеийн эхэнд орсон “е” нь “э”-ээр биш “йэ”-ээр дуудагддагийг бодолцох хэрэгтэй юм. Ер нь үеийн эхэнд “э” (э́пос, диспно́э), үеийн дунд, адагт “е” (трес́т, желе́, пье́са) бичих нь голлож байгаа боловч сүм хийдийн слав бичгийн уламжлалыг дагаад үгийн эхний “е” (Египет, епи́скоп, ева́нгелие гэж) бичсээр байна. Гадаад хэлний уужим “æ”-г “э” болгон лэ́ди, лэндло́рд, плэ́д гэж бичиж байгаа бөгөөд (“э”-ийн өмнө орсон – орч.) “л” нь эдгээр үгэнд Өрнөд Европтоо “l” (§3) гэж дуудагддаг авч одоо хатуу (l) болжээ.

б. Гадаад хэлний хэрэглэгдэхүүнд байдаг давхар гийгүүлэгчийн дуудлага дан байхаасаа ялгаагүй учир ба л || ба л л, ки т || ки т т, пруса́к || прусса́к гэж буулган бичиж байгаа нь харахад л ялгаатайгаас биш сонсоход (хэлж бичүүлэх үед дуудлагыг нь зориуд сунжруулаагүй тохиолдолд) ялгаа байхгүй. Тэр ч атугай, харааны талыг барьж хэл хэлэнд давхар гийгүүлэгчийг ягштал баримтлан бичдэггүй ч явдал бий (*фр.* groupe, soupe, symétrie || *гер.* Gruppe, Suppe, Symmetrie гэх мэт). Орос хэлний зөв бичих зүйн лавлах хэрэглэгдэхүүнд зарим тохиолдолд эх бичгийг даган давхар гийгүүлэгчийг хэвээр нь бичдэг атлаа зарим үед дан бичсэн байдаг. Жиш: ко́рре́ктор, ко́рре́ктóра, ко́рреспондэ́нция гэдэг үгст -rr-ийг хэвээр нь давхарлан бичдэг атлаа ко́нкурэ́нт, ко́нкурэ́нция, ко́ридо́р гэхэд дан бичиж байна.

Орос хэлнээ орсон гадаад үгийн толь бичигт ийн хялбаршуулах аргыг тууштай баримталжээ. Өөрөөр хэлбэл давхар гийгүүлэгч огт оруулсангүй. Харин өмнөх нь өргөлт бүхий хоёр эгшгийн хооронд орсон давхар гийгүүлэгч бүхий үг, тийм үгээс үүссэн үг, мөн оноосон нэрийн хувьд давхар хэвээр нь: *масса* - *массивный*, *массовка*; *колонна* - *колоннада*; *ахилл* - *ахиллесов* гэх мэтээр бичсэн байна.

Тайлбар

Сүүлийн үед дэлхийн янз бүрийн хэлнээс хүний амьдралын бүхий л хүрээнд хамаарах олон тооны үг монгол хэлэнд орж байна. Энэ нь нэг талаас монгол хэлний үгийн санг баяжуулж буй боловч нөгөө талаас тэдгээр үгийг эх хэлэндээ хэрхэн зөв оруулан авах талаар маргааныг дагуулж байна. Өөрөөр хэлбэл харь үгсийг орчуулах, эсвэл шууд авах, хэрэв шууд авбал орчин цагийн монгол хэлний бичлэг, дуудлагын хэм хэмжээг хэрхэн баримтлах, үгүй бол цаад хэлнийхээ бичлэг, дуудлагын онцлогийг хагалзах уу гэх зэрэг асуудал олон нийтийн дунд төдийгүй хэл судлаачдын хувьд ч эргэлзээтэй байгаа билээ. Иймд бид Зөвлөлтийн эрдэмтэн Н.В.Юшмановын боловсруулсан *Грамматика иностранных слов* [Харь гаралтай үгийн хэлзүй] хэмээх бүтээлийг туршлага болгох үүднээс толилуулж байна.

Н.В.Юшманов нь энэхүү хэлзүйг анх 1930-аад онд боловсруулсан ба тэр цагаас хойш хэдэнтээ хэвлэгджээ (1939, 1942, 1979). Энэ нь уг бүтээлийн үнэ цэнэ хуучраагүй хэвээр байгаагийн тод гэрч юм. Энэхүү бүтээл нь харь хэлний үгсийн хэлзүй, олон улсын чанартай нэр томьёо бүтээхэд ордог махбодиуд, латин үсгийн болон грек үсгийн цагаан толгойн хүснэгт, орос болон латин үсгийн дүйцэл, химийн элементийн тэмдэглэгээ, утга зохиолд өргөн хэрэглэгддэг харь хэлний үг, хэллэгүүд гэсэн бүтэцтэй. Бидэнд байгаа мэдээгээр манай ахмад үеийн эрдэмтдийн нэг Ч.Догсүрэн энэ бүтээлийг бүрэн орчуулсан гэх сураг байвч хараахан олдсонгүй, харин уг бүтээлийн эхний 17 зүйлийн орчуулгын машиндмал эхийг энэ удаа бага зэрэг редакторлан олон нийтэд хүргэж байна.

Ч.Догсүрэн нь нэр томьёо судлалын чиглэлээр дагнан ажиллаж, нэр томьёо тогтоох, толилох, жигдлэх хамгийн наад захын шаардлагаас эхлээд уул ажилд зайлшгүй холбогдох

мэдлэгийг эзэмшүүлэх талаар дэс даралдаатай ажил хийж байжээ. Тэрхүү ажлын нэг нь монгол нэр томьёо оноох, толилох, жигдлэх аргазүйн товч зөвлөмж (Догсүрэн, 1988) юм. Ер нь “шинжлэх ухаан, техникийн болон улс ардын аж ахуй, соёлын олон салбарын нэр томьёог зөвхөн хэл шинжлэлийн мэргэжлийн хүмүүс тогтоодоггүй, тэдгээр салбарын нарийн мэргэжлийн хүмүүсийн оролцоо зарим талаар зонхилох үүрэгтэй байдаг” тул Улсын нэр томьёоны комиссоос санаачлан энэхүү аргазүйн зөвлөмжийг тухайн үеийн ЗХУ-ын ШУА-ийн Нэр томьёоны хорооноос боловсруулан баримталж буй зарчим, аргазүйг удирдлага болгон боловсруулжээ. Энэхүү аргазүйг гардан боловсруулсан эрдэмтэн Ч.Догсүрэн олон улсын чанартай нэр томьёо бүтээхэд ордог махбодын жагсаалтыг Ленинградын Улсын Их Сургуулийн профессор Н.В.Юшмановын боловсруулсан *Грамматика иностранных слов* бүтээлийн 1979 оны хэвлэлээс орчуулж оруулсан байдаг. Чухам энэхүү аргазүйн зөвлөмжийг боловсруулж байх үедээ Ч.Догсүрэн гуай Н.В.Юшмановын энд дурдан буй бүтээлийг бүрэн орчуулсан бололтой бөгөөд бидэнд буй орчуулгын эхний хэсгийн машиндмал эхийн нүүрэнд 1983 он гэж тэмдэглэсэн байгаа бөгөөд мөн *Монгол нэр томьёо оноох, толилох, жигдлэх асуудал (аргазүйн товч зөвлөмж)* хэмээх бүтээл УНТКМ цувралын №145-146-д 1988 онд хэвлэгдсэн боловч редакцийн зүгээс “Энэ номын эх материалыг 1986 онд редакцид хүлээн авсан” хэмээн цохон тэмдэглэсэн байдаг (Догсүрэн, 1988:2). Тухайн үед монгол хэлийг шинжлэх ухаан-техникийн утга зохиолын хэлний түвшинд хүртэл хөгжүүлэхэд манай нэр томьёо судлаачид идэвх зүтгэл гарган ажиллаж байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал Улсын нэр томьёоны комиссын Нарийн бичгийн даргаар ажиллаж байсан доктор Ц.Шагдарсүрэн *Нэр томьёо оноох ажлыг боловсронгуй болгох арга зам, Герег, латин гаралтай гаралтай нэр томьёоны махбодийн гол утга* зэрэг цуврал өгүүлэл бичиж хүүхэд, залуучуудын техникийн мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсны учир “Залуу зохион бүтээгч” сэтгүүлийн анхны шагналыг хүртэж байв.

Эдүгээ ч гэсэн нэр томьёо судлалын асуудал улам хурцаар өрнөж монгол хэл шинжлэлийн өдөр тутмын ажил болоод байгаа энэ үед манай ахмад үеийнхний бүтээл, туршлага онол-хэрэглээний хувьд чухал залуур болно хэмээн итгэнэм.

Номзүй

Словарь иностранных слов. Составлен бригадой под общ. руков. гл. ред. Ф.Н.Петрова с приложением таблиц и грамматики, составленной проф. Н.В.Юшмановым. М., 1939, 708 с.

Словарь иностранных слов с приложением таблиц и грамматики, составленной проф. Н.В.Юшмановым. 2-е изд. Ред. Ф.Н.Петрова. М., 1942, 831 с.

Юшманов Н.В. *Грамматика иностранных слов.* Краткое методическое пособие по разработке и упорядочению научно-технической терминологии. М., 1979, стр.59-125.

Догсүрэн Ч. *Монгол нэр томьёо оноох, толилох, жигдлэх асуудал (аргазүйн товч зөвлөмж).* УНТКМ №145-146. Ред. Ц.Шагдарсүрэн. Уб., 1988, 104 х.

Б.Түвшинтөгс